



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож,
тусгай зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, тус хорооны 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зарласан “Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт ХХЗХ-2024/Орхон/FM-01”-ын үнэлгээний ажлын хэсгийн 2024 оны 07 сарын 04-ний өдрийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тус хорооноос зарласан Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт ХХЗХ-2024/Орхон/FM-01”-д Мөнхийн үйлс саруул ХХК-ийг шалгарсанд тооцсугай.
2. Сонгон шалгаруулалтад шалгарсан Мөнхийн үйлс саруул ХХК-д радио өргөн нэвтрүүлгийн радио станцад 87.9 МГц-ийн радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс 2029 оны 07 дугаар сарын 09-ний өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай.
3. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
4. Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

ГИШҮҮД

Г.ЧИНЗОРИГ

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР